

Маягт СЗХ04008

Даатгалын бүтээгдэхүүний мэдэгдлийн маягт

1	Мэдэгдэл огноо	Он	2021	Сар	03	Өдөр	29
2	Мэдэгдэл гаргагчийн оноосон нэр	Амар Даатгал ХХК					
3	Даатгалын бүтээгдэхүүний нэр	Гадаадад зорчигчийн гэнэтийн ослын даатгал					
4	Даатгалын бүтээгдэхүүний холбогдох даатгалын хэлбэр	Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал					
5	Даатгалын бүтээгдэхүүнийг борлуулах тухай эрх бүхий албан тушаалтны шийдвэр	Шийдвэрийн нэр		Огноо		Дугаар	
		Даатгалын бүтээгдэхүүн шинэчлэн батлах тухай		2019-11-21		ЗТ-19/11-018	
6	Цахимаар борлуулах эсэх	Тийм					
7	Даатгалын хураамжийг тооцоолсон актуарч:	Овог		Нэр			
		Доржготов		Уранцэцэг			
Мэдээллийн төрлийг сонгоно уу.							
8	Даатгалын бүтээгдэхүүнийг шинэчлэх						
Даатгалын бүтээгдэхүүний ерөнхий мэдээлэл							
9	Даатгалын зүйл	Амь нас, эрүүл мэнд, эмчилгээний зардал					
	Даатгалын үндсэн эрсдэл	Ердийн болон халдварт өвчин, гэнэтийн осол, нэмэлт зардал					
	Даатгалын нэмэлт эрсдэл						
	Даатгалын хураамжийн хувь, хэмжээ	0.006%-0.6%					

Даатгалын тухай хууль, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан Даатгалын багц дүрэмд нийцүүлэн мэдэгдлийг үнэн зөв бөглөж, хүргүүлэв. Дээр мэдэгдсэн зүйл нь ямар нэг худал ташаа зүйл орсон байвал хариуцлагыг бид хүлээх болно.

ДААТГАЛД ХАМРАГДАХГҮЙ НӨХЦӨЛҮҮД

(Энэхүү нөхцлийн бүх хэсэгт хамааралтай болно.) Энэхүү нөхцлөөр олгогдох даатгалын хамгаалалтад дор дурдсан эрсдэл, түүний үр дагаврын улмаас бий болсон хохирол хамаарахгүй бөгөөд Даатгагч нөхөн төлбөр олгохгүй. Үүнд:

1. Даатгуулагчийн өөрийн буруутай үйл ажиллагаа, гэмт хэргийн чанартай үйлдэлд оролцсоны улмаас эсвэл залилангийн зорилгоор хийсэн, хэт хайрамжгүй, хэт болгоомжгүй үйлдлээс үүссэн хохирол. Даатгуулагчийн сэтгэцийн өөрчлөлтөд орсон үед үйлдсэн болон, сэтгэл мэдрэлийн эмчилгээ хийлгэх үеийн үйлдэл, түүний үр дагавар;
2. Хүний хүчин зүйлээс үл хамаарах байгалийн онц үзэгдлүүд болох үер, газар хөдлөлт, хөрсний гулсалт, галт уулын дэлбэрэлт, хүчит салхи, агаар мандал ба сансраас унах биетүүд, агаар мандлын, цаг уурын, чичирхийллийн болон геологийн онцгой үзэгдэл;
3. Терроризмын үйл ажиллагаа, бослого, үймээн самуун болон олон нийтийн хэт бөөгнөрсөн үйл ажиллагаа, цугларалтаас үүдсэн хохирол;
4. Энхийн цагт цэрэг армийн болон хамгаалалтын хүчний үйлдэл, хохирол;
5. Урьдчилан зарласан болон зарлаагүй дайн байлдааны үйл ажиллагаа, олон улсын хөндлөнгөөс оролцон хүч хэрэглэсэн үйл ажиллагаа, мөргөлдөөн, маргаантай асуудал;
6. Радио идэвхит болон цөмийн эрчим хүчний нөлөөлөл;
7. Даатгуулагч мөрийцөх, аливаад уриалан дуудсан үйлдэл хийх, хэрүүл шуугиан тарих болон зайлшгүй тохиолдолд хуулийн дагуу хувийн болон нийтийн эрх ашгийг хамгаалах, аврах үйл ажиллагаанаас үүдсэн хохирол;
8. Нэмэлт хураамж төлж, гэрээнд тусгайлан тохиролцоогүй нөхцөлд Даатгуулагч даатгуулахаас өмнө өвдсөн байсан өвчин болон гэмтлүүдтэй холбоотой аливаа зардал;
9. Даатгуулагч аливаа уралдаан тэмцээн, спорт арга хэмжээ, урьдчилсан болон бэлтгэл сорилтод биечлэн оролцсон;
10. Автомашин, мотоцикль бусад ижил төстэй тээврийн хэрэгслийн уралдаан тэмцээнд оролцох, ан ав хийх, хиймэл уушги ашиглан усанд шумбах, зорчигч тээврийн бус усан онгоцоор олон улсын далай тэнгист навигацийн тээвэрт оролцох, морь унах, ууланд авирах, бокс тоглох, барилдах, бие хамгаалах урлаг болон шүхрээр буух, халуун агаар бүхий агаарын бөмбөлгөөр нисэх, чөлөөт уналт, гулгалт, эгц хананд авирах зэрэг аюултай спортын төрөлд оролцох;
11. Спортын холбоо болон бусад ижил төстэй байгууллагуудаас зохион байгуулж байгаа уралдаан тэмцээнд оролцох;
12. Цанаар гулгах болон түүнтэй төстэй спорт, өвлийн болон зуны спортын аюултай төрөлд оролцох;
13. Монгол Улсын нутаг дэвсгэрээс гадна байнга оршин суугч оюутнууд;
14. Олон нийгэд үйлчилдэггүй агаарын хөлөг эсвэл нисдэг тэргээр зорчих, ашиглах;
15. Даатгуулагчийн ажил үйлчилгээний үр дагавараас үүдэлтэй гарсан хохирол, ажлын байран дахь осол;
16. Давагдашгүй хүчин зүйлсийн нөлөөлөл;

Дараах тохиолдолд: Даатгагч нөхөн төлбөр олгохоос татгалзах эрхтэй. Үүнд:

1. Нэн яаралтай, зайлшгүй тохиолдлоос бусад тохиолдолд Даатгуулагч болон түүний өмнөөс MAPFRE Asistencia-д урьдчилан мэдэгдэлгүйгээр эсвэл уг байгууллагын албан ёсны зөвшөөрөлгүйгээр хүлээн авсан аливаа үйлчилгээ;
2. Хэрэв нэн яаралтай болон зайлшгүй тохиолдолд үйлчилгээ үзүүлэх шаардлага гарсан бол Даатгагчид холбогдох баримт, тооцоо, нэхэмжлэлийн эх баримтыг бүрдүүлж ирүүлэх шаардлагатай;
3. Даатгуулахаас өмнө өвдөж байсан аливаа архаг хууч өвчин эмгэг, гэмтэл;
4. Амиа хорлох, мөн амиа хорлохоор завдсанаас биед учирсан гэмтэл, хожим үүссэн нөлөөнүүд;
5. Архи, хар тамхи, хортой эм хэрэглэсэн, хар тамхины хольц бүхий мансууруулах үйлчилгээтэй эм тариа хэрэглэсэн, эмчийн жоргүй хэрэглэхийг хориглосон эм тариаг дур мэдэн хэрэглэсэн, ухаан санаанд нөлөөлөхүйц болон мэдрэлийн тэнцвэр алдагдуулах үйлчилгээтэй эм хэрэглэснээс үйлдэлтэй өвчин, түүний үр дагавар;
6. Даатгагчийн эмч мэргэжилтнүүдийн зөвшөөрсөн тохиолдолд Даатгагчийн санал болгосон шилжүүлэх, тээвэрлэх асуудлыг Даатгуулагч болон түүнийг төлөөлж буй хүмүүс татгалзсан, хойшлуулсан;
7. Нөхөн сэргээх эмчилгээ;
8. Протез (хиймэл эрхтэн), ортопед, остесинтез материал, нүдний шил;
9. Эмэгтэйчүүдийн эмчийн үзлэг, жирэмслэлт, төрөлт, үр хөндөлт болон тэдгээрийн хүндрэлүүд;
10. Ачаа тээшний баглаа боодлын болон тэмдэг тэмдэглэгээний хангалтгүй байдал, хагарч хэмхрэх болон амархан муудах тээш зэргээс үүдэн гарсан үр дагавар;

Дараах тохиолдолд даатгалын үйлчилгээ болон нөхөн төлбөр олгогдохгүй. Үүнд:

1. Даатгалын гэрээ хүчин төгөлдөр үйлчлэх хугацаанаас өмнө учирсан аливаа өвчин, гэмтэл, хохирол;
2. Эмнэлэгийн туслалцаа, эмчилгээ авах зорилготойгоор гадаад оронд зорчсон;
3. Үл анагаагдах өвчний онош тавигдсаны дараа гадаад оронд зорчсон;
4. Гадаад оронд зорчихоос өмнөх 12 сарын хугацаанд Даатгуулагч эмчилгээ хийлгэж байсан, эмнэлэгийн хяналтанд байсан үедээ эмчийн зөвшөөрөлгүйгээр зорчсон;
5. Даатгуулагч байнгын оршин суугаа газартаа байх хугацаанд гарсан аливаа зардал, даатгалын гэрээгээр хамгаалагдаагүй аливаа эрсдэлүүд, даатгалын хугацаа дууссан, эсвэл гадаад оронд зорчсоноос хойш 92 хоногийн дараа гарсан аливаа зардал.